



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/348

Номгон

Богд сумын баяр наадам тэмдэглэх
товийг өөрчлөн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Сумдын баяр наадам тэмдэглэх тов тогтоох тухай” А/359 дүгээр захирамжаар тогтоосон товд өөрчлөлт оруулахаар Богд сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сумын баяр наадмыг 2026 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулахаар өөрчлөн тогтоосугай.

2. Баяр наадмын хурдан морь унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэн, үр дүнг танилцуулж, тусгай төрлийн баримтыг бүрдүүлж Төрийн архивд шилжүүлэхийг Богд сумын Засаг дарга (Л.Ганаа)-д үүрэг болгосугай.

3. Сумын баяр наадмыг тэмдэглэхдээ малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллахыг Богд сумын Засаг дарга (Л.Ганаа)-д зөвлөсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ